



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАТШИРЭЭТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 09 сарын 17 өдөр

Дугаар А/106

Эг

Г Бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх Г
дархлаажуулалтын ажлыг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дүгээр зүйлийн 66.1, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5, 6.6, 9 дүгээр зүйлийн 9.4, 9.5, 9.6, 9.7, 9.8, 9.9, 11 дүгээр зүйлийн 11.1.1 дэх хэсэг, аймгийн Мал эмнэлгийн газрын даргын 2024 оны 9 дүгээр сарын 17-ны өдрийн А/51 тоот тушаал, аймгийн Засаг даргын 2024 оны А/472 тоот захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Малын архаг халдварт бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх 2024 оны төлийг дархлаажуулах ажлыг 2024 оны 9 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн чанартай, маршрутын дагуу хийж гүйцэтгэх, туслах ажилчдын хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж, зааварчлага өгч ажиллахыг Шүтээн дэнж ХХК-ийн захирал Б.Мягмаржав, Баянбараат Хайрхан ХХК-ийн захирал Т.Бямбадорж нарт үүрэг болгосугай.

2. Урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажилд мал сүргээ товлосон хугацаанд тарилгын хашаа бүхий газар авчирч бүрэн хамруулж, тарилгын явцад малын эмч мэргэжилтнүүдэд туслалцаа үзүүлэн хамтран ажиллах малчид, мал бүхий иргэдийг татан оролцуулж хүн хүчээр хангаж, хяналт тавьж ажиллахыг багийн Засаг дарга нарт даалгасугай.

3. Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх ажлын явц гүйцэтгэлд хяналт тавьж мэргэжил арга зүйн заавар, зөвлөмжөөр хангаж ажиллахыг Мал эмнэлгийн улсын байцаагч Ж.Ундрах үүрэг болгосугай.

4. Дээрх аж ахуйн нэгжүүдэд олгох вакцины хуваарь, дархлаажуулалтад хамрагдах малын тоог хавсралтаар баталсугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНСҮХ

202401353

Сумын Засаг даргын 20²⁴ оны 09 р сарын 17-ны
өдрийн А/106 тоот захирамжийн хавсралт



2024 ОНД БРУЦЕЛЛЁЗ ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ
ДАРХЛААЖУУЛАЛТАД ХАМРАГДАХ МАЛ, ВАКЦИНЫ ХУВААРЬ

№	ААНэгжийн нэр	Малын тоо				Вакцин /тун/	Шингэлэгч /литр/
		тугал	хурга	ишиг	Нийт		
1	Баянбараат хайрхан ХХК	2800			15920	2800	18,800
			8547	4653		13200	
2	Шүтээн дэнж ХХК	2720			2800	2720	5,400
Дүн		5520	8547	4653	18720		24,200

ХУВААРЬ ГАРГАСАН:
МАЛ ЭМНЭЛГИЙН УЛСЫН БАЙЦААГЧ

Ж.УНДРАХ